

## ТАНИЛЦУУЛГА

“Усан замын тээврийн тухай” хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах хуулийн төслийн тухай

Манай Улсад Усан замын тээвэр 1950-иад оноос үүсэн хөгжиж 1980-аад оны сүүл хүртэл ОХУ-аас импортолж буй өргөн хэрэглээний бараа, шатах тослох материал бусад ачааг 1 чирэгч усан онгоц, 3 чиргүүл онгоцоор Хөвсгөл нуураар Ханх, Хатгал боомтын хооронд тээвэрлэж байв.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос хойш, ОХУ-аас импортлох барааны ачаа эргэлт үгүй болсон, мөн байгаль орчны асуудлаас болж усан замын тээвэр 2003 оныг хүртэл зогсонги байдалд орсон юм.

Өнөөгийн байдлаар усан замын тээврийн үйлчилгээг хувийн хэвшлийн иргэн, аж ахуйн нэгжүүд эрхэлж, ихэвчлэн аялал жуулчлал, зарим үед эрдэм шинжилгээ судалгааны зориулалтаар бага оврын усан онгоц, завиудыг Хөвсгөл нуурт ашиглаж амрагч, жуулчид, судлаачдыг тээвэрлэж байна. Тухайлбал, 2003 онд Хөвсгөл нуурт 10 хүрэхгүй усан замын тээврийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байсан бол өнөөдөр 80 гаруй болж жил бүр тоо нь нэмэгдэж байна.

2003 онд батлагдсан Усан замын тээврийн тухай хуульд усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтад тавих мэргэжлийн болон дотоод хяналтын асуудал бүрэн тусгагдаагүйгээс усанд хүний амь нас осолдох тохиолдол буурахгүй, осол зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Тухайлбал, 2013 оны 12 дугаар 31-ний байдлаар улсын хэмжээнд усны ослын 117 тохиолдол гарч, 20 аймаг, 52 суманд 119 хүн нас барсан бол, 2014 оны 12 сарын байдлаар 84 тохиолдол гарч, 18 аймаг, 52 суманд 94 хүн нас барсан байна.

Иймд энэхүү осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, усан замын тээврийн аюулгүй байдлын хяналтын асуудлыг тусад нь бүлэг болгож хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарч байна.

Мөн Усан замын тээврийн салбарт 2003 оноос өнөөг хүртэл улсын төсвөөс 3 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн ч Хөвсгөл нуурт баригдсан усан замын тээврийн хэрэгслийн 5 зогсоол, усан замын тэмдэг, тэмдэглэгээний ашиглалт, хамгаалалт, хадгалалт нь төдийлөн үр дүнтэй бус байгаад дүгнэлт хийж энэ ажлыг хариуцах субъектыг тодорхойлох шаардлага гарч байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 11 дэх заалтад далай ашиглах болон усан замын тээврийн асуудал нь Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан.

Төрийн захиргааны төв байгууллагын зарим чиг үүргийг төрийн, төрийн бус болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бодлогын хүрээнд усан замын тээвэрлэлттэй холбоотой дээр дурдсан үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага (“Далайн захиргаа” ТӨҮГ) хэрэгжүүлэхээр хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгах нь зүйтэй байна.

Энэхүү байгууллага нь тус яамны харъяанд 2007 онд байгуулагдсан бөгөөд далайн тээврийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид зааснаар тус байгууллага нь Засгийн газрын өмнөөс олон улсын өмнө үүрэг, хариуцлага хүлээсэн Төрийн захиргааны байгууллага юм.

“Усан замын тээврийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэхүү хуулийн төсөл нь дээр дурьдсан нөхцөл байдлыг хууль, эрх зүйн хувьд шийдвэрлэх чухал ач холбогдолтой юм.

Мөн “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”-д заасныг баримтлан “Усан замын тээврийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙН  
САЙД

Д.ДОРЛИГЖАВ

БАТЛАВ.

ЗАМ, ТЭЭВРИЙН  
САЙД

М.ЗОРИГТ

20... оны ... дугаар сарын  
... -ны өдөр

20... оны ... дугаар сарын  
... -ны өдөр

“УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ” ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон**  
**хууль, эрх зүйн шаардлага**

“Усан замын тээврийн тухай” хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталж, усан замын тээврийн эрх зүйн орчныг зохих хэмжээгээр бүрдүүлсэн билээ.

Энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш улс орны эдийн засгийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарсан бөгөөд аялал, жуулчлалын зорилгоор усан замын тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу төрийн хяналтыг хэрэгжүүлэх, усан замын тээврийн хэрэгслүүдэд техникийн үзлэг хяналтыг төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад мэргэжлийн байгууллагын зүгээс хийх, тэдгээрийг улсын бүртгэлд бүртгэх явцад хуримтлуулсан туршлага, доор дурдсан бодлогын баримт бичигт нийцүүлэн уг хуулийн зарим зохицуулалтыг боловсронгуй болгон сайжруулах шаардлага гарч байна.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 5.3-т тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 4 дүгээр тэргүүлэх чиглэл-дэд бүтцийн хөгжлийн бодлогын хүрээнд “дэд бүтцийг хүн ам, хэрэглэгчийн болон эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ” гэж, мөн бодлогын баримт бичгийн 5.3.1-т тусгагдсан Зам, тээврийн хөгжлийн бодлогын **нэгдүгээр үе шат (2007–2015 он)**-ны Зам, тээврийн салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох Стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд “... усан замын тээврийн тухай хуулиуд, холбогдох стандартууд, дүрэм журмуудад өөрчлөлт оруулахын зэрэгцээ зарим хуулийг шинээр баталж мөрдүүлэх; олон улсын конвенц, стандарт, шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тээврийн гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчилж, олон улсад нийтээр дагаж мөрдөх гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох”; Далайн болон усан замын тээвэрт хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалт хийх таатай орчинг бүрдүүлж, үйл ажиллагааг нь өргөтгөх Стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд “усан замын тээврийг хөгжүүлж, орчин үеийн хөлөг онгоцтой болж, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих” гэсэн зорилтууд; мөн Зам, тээврийн хөгжлийн бодлогын **хоёрдугаар үе шат (2016-2021 он)**-ны Зам, тээврийн салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох Стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд: “...усан замын тээврийг хөгжүүлэх...” гэсэн зорилтууд нь энэхүү хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.

## **Хоёр Практик шаардлага:**

Усан замын тээврийн тухай” хууль нь улс орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байсан тэр цаг үеийн нөлөөгөөр усан замын тээврийн бүх зохицуулалтыг төрийн захиргааны төв байгууллагад төвлөрүүлсэн байсныг тухайн орон нутгийн болон харъяа мэргэжлийн байгууллагын эрх үүрэг, хариуцлагад хамааруулах шаардлага хуулийг мөрдөх хугацааны явцад амьдралаас урган гарч байна. Тухайлбал,

- Усан замын тээврийн тухай хуульд усан замын тээврийн хэрэгслийн болон усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчийн даатгал, хариуцлагын даатгал, зорчигчдын амь насны даатгалын асуудал тусгагдаагүй;

- усан замын тээврийн асуудлаарх төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг тодорхой бус, усан замын тээврийн аюулгүй байдалд тавих хяналтын механизм зохицуулагдаагүй;

- байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх үүднээс усан замын тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол байгуулах, засвар үйлчилгээ хийх, тэдгээрийг шатах тослох материалаар хангах цэг, зорчигчдод үйлчлэх, тасалбар худалдаалах цэг байгуулах зэрэг асуудал зохицуулагдаагүй;

- хуулийн нэр томъёог аялал жуулчлалын хэрэгцээ шаардлагад, түүний дотор улс хоорондын аялал зугаалгад нийцүүлж өөрчлөн шинэчилж, тодорхой болгох;

- усан замын тээврийн хэрэгслээр зорчиж байгаа иргэн, усан замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээд, болон бусад этгээд усан замын тээврийн хууль тогтоомжийг зөрчсөн, усан замын тээврийн хэрэгслийн осол, зөрчил, сүйрэл гарсан тохиолдолд буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох юм.

Монгол Улсын усан замын тээврийн өнөөгийн тогтолцоо, бүтэц зохион байгуулалтад тулгамдсан дээр дурдсан нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс усан замын тээврийн ажил үйлчилгээний чанар, хүртээмж хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг үр ашигтай хангаж чадахгүйд хүрэх нөхцөл байдал үүсч байгаа зэрэг үндэслэл шаардлагын дагуу “Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль”-ийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

## **Гурав. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлд Усан замын тээврийн тухай хуульд нэмэлтээр оруулах хэсэг, заалтыг, 3 дугаар зүйлд хуулийн өөрчлөн найруулах бүлэг, хэсэг, заалтыг, 4 дүгээр зүйлд хуулийн өөрчлөх заалт, 5 дугаар зүйлд хуулиас хасах хэсэг, заалтыг, хууль хүчин төгөлдөр болох хугацааг 6 дугаар зүйлд тусгана.

Хуулийн төсөл нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй одоогийн хуулийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлж байгаа ч хуулийн зарим

хэсэг, зүйл, заалтыг өөрчлөн найруулж, агуулгыг нарийвчлах, шинээр бүлэг, хэсэг, зүйл заалт нэмэх, алдаатай өгүүлбэрийг найруулах, зарим зүйл заалтыг хасах болон салбарт шинээр бий болж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг даган нэвтэрч буй нэр томъёог Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлнэ.

Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллага, бусад холбогдох байгууллага, нэгжийн бүрэн эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

Хуулийн төсөл нь хүн ам, хүрээлэн буй орчинд ээлтэй, зах зээлийн эрэлтэд нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий усан замын тээврийн үйлчилгээ, салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэхэд түлхэц болно.

### **Дөрөв.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар усан замын тээврийн талаар төрийн захиргааны төв ба түүний харъяа байгууллагын хэрэгжүүлэх эрх хэмжээний асуудал тодорхой болж, усан замын тээврийн үйлчилгээ, үйл ажиллагааны эрх зүйн орчин сайжирна.

Түүнчлэн Монгол Улсын усан замын тээврийн мэргэжилтэй боловсон хүчин сургаж бэлтгэх, мэргэшүүлэх бодлого тодорхой болж, ажлын байр шинээр бий болгох, тэднийг усан онгоцны үйл ажиллагааны зохих дадал туршлагатай болгож, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, цаашид манай улс өөрийн усан онгоцоор зорчигч, худалдааны ачаа тээвэрлэх үйл ажиллагаанд оролцох боломжтой болно.

### **Тав. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн үялдах, үг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

“Усан замын тээврийн тухай” Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцэж байгаа бөгөөд Монгол Улсын бусад хууль тогтоомжид шинээр нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар  
сарын ..... ны өдөр

Улаанбаатар хот

### УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Усан замын тээврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/ 3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалт:**

“3.1.13. “усан замын төв буудал” гэж усан замын тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх, түлш, шатахуунаар цэнэглэх, зорчигчид амрах, хүлээх танхим, хоолны газар, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эмчилгээний өрөө бүхий цахилгаан эрчим хүчээр хангагдсан, аврах хэрэгслээр тоноглогдсон усан замын тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоолыг”;

#### **2/ 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалт:**

“3.1.14. “усан замын тээврийн хэрэгслийн жолооч” гэж энэ хуулийн 3.1.3-т заасан (нийт жин нь 200 кг-аас доошгүй, 8 киловаттаас багагүй хүчин чадалтай хөдөлгүүр бүхий) усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчийг”;

#### **3/ 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалт:**

“3.1.15. “улс хоорондын тээвэрлэлт” гэж Автотээврийн тухай Монгол Улсын хуулийн 3.1.7.-д заасныг ойлгоно”;

#### **4/ 3 дугаар зүйлийн 3.1.16 дахь заалт:**

“3.1.16. “жуулчин тээвэрлэлт” гэж Автотээврийн тухай Монгол Улсын хуулийн 3.1.13.-т заасныг ойлгоно”;

#### **5/ 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт:**

“6.1.8. усан замын тээврийн салбарын боловсон хүчин хүний нөөцийг сургаж бэлтгэх, гэрчилгээ олгох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах”;

#### **6/ 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг:**

“14.4.Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч эзэмшигч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд заавал даатгуулна”;

#### **7/ 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:**

“12.3.Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолоодогч нь аялалын хугацаанд доор дурдсан үйлдэл хийхийг хориглоно.

12.3.1.согтууруулах ундаа, мансууруулах үйлчилгээтэй эм, бодис уусан үедээ усан замын тээврийн жолоодох;

12.3.2.согтууруулах ундааны зүйл уусан эсэхээ усан замын тээврийн хяналтын улсын байцаагч, бусад эрх бүхий албан тушаалтанд шалгуулахаас зайлсхийх;

12.3.3.зорчигч, аялагч тээвэрлэж явахдаа тэдний анхаарал, сонирхлыг татах зорилгоор усны мандалд огцом эргэлт хийх;

12.3.4.аврах хантаазгүй болон стандартын бус, шаардлага хангахгүй аврах хантаазаар зорчигч, аялагчийг тээвэрлэх;

12.3.5.хөдөлгөөнд оролцохдоо бусад усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд аюул учруулахаар гүйцэж түрүүлэх, буруу зөв талаар зөрж өнгөрөх, хөдөлгөөний чиглэлийг нь сүлжих, урдуур хойгуур нь тойрохыг тус тус хориглоно”.

#### **8/ 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь хэсэг:**

“16.1.5.Энэ хуулийн 12.3.1, 12.3.2-т заасныг зөрчсөн усан замын тээврийн хэрэгслийн жолоодогчийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэгээс хоёр жил хүртэл хугацаагаар хасна”;

#### **9/ 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь хэсэг:**

“16.1.6.Энэ хуулийн 12.3.3-т заасныг зөрчсөн усан замын тээврийн хэрэгслийн жолоодогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгууль ногдуулна”;

#### **10/ 16 дугаар зүйлийн 16.1.7 дахь хэсэг:**

“16.1.7.Энэ хуулийн 12.3.4-т заасныг зөрчсөн усан замын тээврийн хэрэгслийн жолоодогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээгээр, давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулна”;

#### **11/ 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь хэсэг:**

“16.1.8.Энэ хуулийн 12.3.5-т заасныг зөрчсөн усан замын тээврийн хэрэгслийн жолоодогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр, давтан үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгууль ногдуулна”;

**2 дугаар зүйл.** Усан замын тээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “тэмдэг бүхий” гэсний дараа “байгалийн болон хиймлээр барьж байгуулсан” гэж; 3.1.3 дахь заалтын “ачаа тээвэрлэхэд зориулсан” гэсний дараа “нийт жин нь 200 кг-аас доошгүй, 8 киловаттаас доошгүй хүчин чадалтай хөдөлгүүр бүхий” гэж; 3.1.11 дэх заалтын “...эрэг” гэсний дараа “болон түүнтэй залгаа “усан” гэж; 3.1.12 дахь заалтын “тэмдэглэгээ хийж” гэсний дараа “тээвэрлэгчээс” гэж; 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “хэрэгжүүлэх” гэсний дараа болон мөн зүйлийн 7.1.5 дахь заалтын “хяналт тавих” гэсний дараа “санхүүжилтийг жил бүрийн улсын төсөв, бусад эх үүсвэрт тусгаж, шийдвэрлүүлэх” гэж; 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын “...төрийн захиргааны төв байгууллагад” гэсний дараа “болон түүний эрх олгосон төрийн захиргааны байгууллагад” гэж; 8.3 дахь заалтын “...төрийн захиргааны төв байгууллагаас” гэсний дараа “болон түүний эрх олгосон төрийн захиргааны байгууллагаас” гэж; 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “шаардлагыг хангасан байдалд усан” гэсний дараа “замын” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Усан замын тээврийн тухай хуулийн дараах бүлэг, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:**

“3.1.6 “Зорчигч” гэж усан замын тээврийн хэрэгсэл дээр буюу тавцан дээр зорчиж буй зорчих тасалбар болон бусад баримт бичгээр зорчих эрхээ баталгаажуулсан этгээдийг;

**2/ 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт:**

“6.1.5.тээвэрлэлтийн үйл ажиллагаа, усан замын тээврийн хэрэгсэл, усан замын зогсоол, төв буудал, аврах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах”;

**3/ 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт:**

“7.1.4.усан замын олон улс, улсын чанартай тээвэрлэлтийн чиглэлийг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно. Орон нутгийн усан замын сүлжээн дэх зорчигч тээвэрлэлтийн чиглэл, ажил үйлчилгээний эхлэх дуусах хугацаа, хөвөлтийн бүсийг тухайн орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагатай хамтран батлах” гэж;

**4/ 12 дугаар зүйлийн 12.2.7 дахь заалт:**

“12.2.7.өөрийн барьж байгуулсан усан замын зогсоолыг шаардлагад нийцүүлэн тоноглож, бусад тээвэрлэгчийн болон нийтийн эзэмшлийн зогсоолыг арчлан хамгаалах, ашиглах”;

**5/ “Зургаадугаар бүлэг. Усан замын тээврийн хяналт**



## **“15 дугаар зүйл.Усан замын тээврийн хяналтыг хэрэгжүүлэх**

15.1.Усан замын тээврийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд төрөөс тавих хяналтыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх хяналтын алба, ерөнхий байцаагч, усан замын тээврийн хяналтын ахлах байцаагч, байцаагч хэрэгжүүлнэ.

15.2.Ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, ахлах байцаагч, байцаагчийн эрхийг ерөнхий байцаагч тус тус олгоно.

15.3.Улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ тусгай дүрэмт хувцас өмсөх ба шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдсан, усан замын тээвэрт ашиглаж байгаа барилга байгууламж, зогсоол, усан замын тээврийн хэрэгсэлд чөлөөтэй нэвтрэх, зорчих эрхтэй”

**4 дүгээр зүйл.**Усан замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “буюу” гэснийг “болон” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “гэрчилгээ олгоно” гэснийг “гэрчилгээ олгож, тухай бүр тэмдэглэл хийнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Усан замын тээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “нийтийн” гэснийг, мөн зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ... ний өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2015 оны 09 дүгээр сарын 28

Дугаар . . .

Улаанбаатар хот

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэх тухай.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэж Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад дараах үүргийг өгөв. Үүнд:

1. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

2. Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалын төслийг Хууль зүйн сайдтай хамтран батлуулах арга хэмжээ авах.

3. Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалын дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

ГАРЫН ҮСЭГ

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2015.09.24

Хуулийн төсөл батлагдсанаар дор дурдсан асуудлууд шийдвэрлэгдэнэ.  
Үүнд:

1. Мөрдөгдөж буй хуульд усан замын тээврийн хэрэгслийн болон усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчийн даатгал, хариуцлагын даатгал, зорчигчдын амь насны даатгалын асуудал тусгагдаагүй.

Иймд усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч хэн байхаас үл хамааран жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд заавал даатгуулна гэж хуулийн төсөлд тусгасан. Энэхүү заалт нь усан замын тээврийн хэрэгслийн ослын улмаас хүний амь нас үрэгдсэн үед хохирогчид нөхөн төлбөр олгох, учирсан хохирлыг барагдуулах зэрэг олон асуудлыг зохицуулахад чухал ач холбогдолтой.

Даатгуулагчийг үүргээ биелүүлэх хөшүүрэг болгох зорилгоор даатгалд даатгуулаагүй тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийг бүртгэх, бүртгэлийн дугаар олгохгүй байх тухай заалтыг мөн оруулсан.

2. Хуулийн 7 дугаар зүйл. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн 7.1.4 дэх заалт, хуулийн 6 дугаар зүйл. Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн 6.1.4 дэх заалтууд агуулгын хувьд давхардсан тул орон нутгийн Засаг даргын бүрэн эрхэд оруулж өөрчлөн найруулж усан замын тээврийн асуудлаарх төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын эрх үүргийг тодорхойлов.

3. Усан замын тээвэр, тээвэрлэлтийн үйл ажиллагааны аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг сайжруулах зорилгоор хуулийн 6 дугаар бүлгийн нэрийг “Усан замын тээврийн хяналт” гэж өөрчлөн, усан замын тээврийн хяналтыг хэрэгжүүлэх субъект, түүний бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагааны зохицуулалтыг тусгаж хуулийн 15 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан.

4. Байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх үүднээс усан замын тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийх, тэдгээрийг шатах тослох материалаар хангах цэг, зорчигчдод үйлчлэх, тасалбар худалдаалах цэг бүхий нэгдсэн зогсоол байгуулах асуудлыг зохицуулах зорилгоор “усан замын төв буудал” нэр томъёо шинээр нэмж, хуулийн бусад нэр томъёог өнөөгийн хэрэгцээ шаардлага, бусад хуульд нийцүүлж өөрчлөн шинэчилж, тодорхой болгож томъёолсон.

5. Усан замын тээврийн хэрэгслээр зорчиж байгаа иргэн, хуулийн этгээд, усан замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд усан замын тээврийн хууль тогтоомжийг зөрчсөн, усан замын тээврийн хэрэгслийн осол, зөрчил, сүйрэл гарсан тохиолдолд буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо өнөөгийн шаардлагад нийцэж боловсронгуй болох юм.

ДАЛАЙ АШИГЛАЛТ, УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ  
ХЭЛТЭС